



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 4/37

Мандалговь


“Хүмүүнлэгийн арга хэмжээг дэмжих тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3”а”, 29.1.6 ”б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын малчин болон мал бүхий өрх, иргэдийг байгалийн гэнэтийн аюул ган, зуд хүн малын халдварт өвчний болзошгүй эрсдэлээс хамгаалах , эрсдэлийн үед хүмүүнлэгийн тусламж, дэмжлэгт малчид, иргэдийг бүрэн хамруулах зорилгоор хүмүүнлэгийн гишүүнчлэлийг дэмжсүгэй.

2.Хүмүүнлэгийн гишүүнчлэлийн татварыг гэрээний дагуу Засаг даргын нөөцийн зардлаас шилжүүлэхийг Тамгын газрын дарга (Б.Оюунчимэг), ня-бо (О.Бямбасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ